



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2018 оны 03 сарын 06 өдөр

Дугаар 59

Улаанбаатар хот

Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 2, 28 дугаар зүйлийн 5 дахь хэсэг, Засгийн газрын 2001 оны 134 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлэх журам”-ын 11, 17 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 119 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн төлбөрийн жишиг үнэ”-д дор дурдсан агуулга бүхий дараах заалтыг нэмсүгэй:

1/2.8 дахь заалт:

2.8.Төрийн тусгай болон дотоодын цэргийн хамгаалалтад байдаг төрийн өмчийн хуулийн этгээдийн цайны газрын үйлчилгээний хэсгийн 1 м.кв талбайн үнийг 60 хувиар хөнгөлж, талбайн хэмжээг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраар хянуулж байх.

2/7 дахь заалт:

7.Технологийн болон үйл ажиллагааны үндсэн чиглэлээс бусад зориулалтаар байр талбайг бусдад эзэмшүүлж ашиглуулахад түрээсийн гэрээ байгуулж, түрээсийн орлогоос улсын төсөвт төвлөрүүлж байна.

3/8 дахь заалт:

8.Дараах хөрөнгийн түрээсийн төлбөрийн жишиг үнийг зориулалтаас нь хамаарч эд хөрөнгийн ашиглалтын хугацаа, элэгдэл хорогдлын шимтгэл, ашиглалтын нөхцөл, зах зээлийн дундаж үнэ зэргийг харгалзан түрээслүүлэгч тогтоож, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраар баталгаажуулна:

8.1.Төрийн өөрийн өмчийн хөдлөх эд хөрөнгө;

8.2.Бэлэн мөнгөний автомат машин, ундааны машин, антен, тоног төхөөрөмж, кабель;

8.3.Төрийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй орон сууц.

2.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 119 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн төлбөрийн жишиг үнэ”-ийн дараах заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай.

1/2.1 дэх заалт:

2.1.Нийслэл Улаанбаатар хотын төвөөс алслагдмал бүс, дүүрэгт (Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэр дэх Зайсан орчим үл хамаарна) байршилтай эд хөрөнгийг түрээслүүлэхэд түрээсийн төлбөрийн жишиг үнийг 40 хүртэл хувиар;



2/2.4 дэх заалт:


2.4.Аймгийн төвд үйл ажиллагаа явуулж буй төрийн өмчит төрийн өмчит аж ахуйн нэгж, төсөвт байгууллагын түрээслүүлж буй байрны түрээсийн төлбөрийн нэгдүгээр бүсчлэлд хамаарах жишиг үнийг 50 (Дархан-Уул, Орхон аймгийн төвд 40), сумдад 60 хувиар.

3.Энэхүү тогтоолыг 2018 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

4.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТСИЙН  
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Ц.НЯМ-ОСОР

Э.ЭРДЭНЭХИШИГ

Хүрэг  
Хяналтын  
Боловруулсан: